

Батлав. " Ай Эф Соонс" ХХК-ийн захирал
.....Ш.Энхзаяа

Зөвшөөрсөн: НБОГ-ын орлогч

Дарга.....С.Санжмятав

Хянасан: НБОГ-ын Хүрээлэн буй орчин,
Байгалийн нөөцийн хэлтсийн
Мэргэжилтэн.....Ж.Батзолбоо

**НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗУУН МОДНЫ ЭЛСНИЙ УУРХАЙН 2022
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН /ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ: MV-001903/**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: "АЙ ЭФ СООНС" ХХК

Боловсруулсан:

"Ай Эф Соонс" ХХК-ийн БО-ны ажилтан

Ж.Аюур

Улаанбаатар 2022 он

Нэг.Төслийн товч танилцуулга

“Ай Эф Соонс” ХХК-ийн Налайх дүүргийн Зуун модны элсний ордын MV-001903 тусгай зөвшөөрлийн талбайд “Универсальгео”ХХК геологи хайгуулын ажил гүйцэтгэн, нөөцийн тооцоо хийж, 2009 онд нөөцийн хэмжээг Эрдэс Баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан бөгөөд Техник эдийн засгийн үндэслэлийг “Эрдэнэс инженеринг” ХХК боловсруулсан болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг "Газар- Эко" ХХК хийсэн бөгөөд 2019 онд "Их айлчин" ХХК уг үнэлгээнд нэмэлт тодотгол хийж, шинэчлэн боловсруулсан.

Уг тусгай зөвшөөрлийн 11,4 га талбайн элсний давхаргын ашиглалтын нөөцийг В зэрэглэлээр 632,6 мянган м.куб, хайрга элсний хольцын давхаргын нөөцийг С зэрэглэлээр 187,7 мянган м.куб гэж тогтоожээ.

MNS 392:98-ын 1,3,4 стандартын элс хэрэглэгчид уг ордын элсийг шууд ашиглах боломжтой.

Харьяалал \ордын байршил\. Нийслэлийн Налайх дүүрэг, 5-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос 60 км-т байрладаг.

Ажилласан жил. 2010 оноос төслийн үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд 12 дахь жилдээ амжилттай ажиллаж байна.

Үр ашигтай эсэх

Зуун модны элс нийлүүлэх боломжтой салбар:

- Стандартад нийцсэн элсийг барилга байгууламжид шууд нийлүүлэх

- Хөнгөн бетон гулдмай
- Сийрмэг бетон
- 200-300 маркийн царууц бетон эдэлхүүн

Цаашид хэдэн жил ажиллах. ТЭЗҮ-д тусгасны дагуу 6 жил ажиллана.

Тоног төхөөрөмж. БНХАУ-д үйлдвэрлэсэн 25 тонны даацтай 1 ширхэг өөрөө буулгагч, 5 тонны багтаамж бүхий шанагатай 2 авто ачигч, 3 фракцийн шигшигч, цахилгааны трансформатор зэрэг болно.

Ажиллах хүчний талаар. Одоогийн байдлаар 5 орон тоотой ажиллаж байна. Төслийн хүрээнд том оврын автомашин, шигшүүр, ковшийн операторийг өөрийн хөрөнгөөр сургаж бэлтгэсэн бөгөөд цаашид хос мэргэжил эзэмшүүлэхээр төлөвлөж байна. Үүнд аюулгүй ажиллагаа, байгаль хамаалах, гагнуур, цахилгааны мэргэжил орно.

Байгаль орчны төлөв байдал:

1. Физик газар зүйн тодорхойлолт

1903 тусгай зөвшөөрлийн талбай нь Нийслэлийн Налайх дүүрэгт хамаарах бөгөөд Улаанбаатар хотоос 60 км, дүүргээс 18 км, зүүн зүгийн төв замын хойд хэсэгт оршдог. Талбайн орчимд агаарын дулааны хэмийн өөрчлөлт ихтэй, эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаардаг. Хамгийн их хур тундастай үе нь 5-9 сар, бага хур тундас буух үе нь 12 сараас 3 сарын сүүлч. Агаарын хэм 6-8 сард хамгийн өндөр буюу 32°-38° хүрэх үе бий. Хамгийн Хавар салхины хүч ихсэж, 4-5 сард заримдаа 20-28 м\сек хүрэх тохиолдол гардаг байна.

2. Гидрогеологи. Өмнөх судлаачдын ажлын үр дүнгээр 8 уст үе, ан цавын усны бүрдэл ялгасан байна. Эдгээрээс тухайн дүүрэгт доорх уст үе, бүрдлүүд хамрагдана.

1. Дээд голоценийн аллювийн хурдасны уст үе
2. Доод голоценийн аллюви-проливийн хурдасны уст үе
3. Дээд плейстоценийн пролюви-делювийн хурдасны уст үе
4. Неогений хурдасны уст комплекс

3. Хөрс, ургамал, амьтан. Тусгай зөвшөөрлийн талбай 11,4 га хэмжээтэй, өргөрөг дагуу 770м, уртраг дагуу 295м талууд бүхий тэгш өнцөгт гурвалжин хэлбэртэй. Өвс ургамлын бүрхэвчээр ядмаг, алаг цоог тархсан. Мод бут, сөөггүй. Талбайн ямарч хэсгээр машин тэрэг саадгүй явах боломжтой. Амьтан ажиглагдаагүй.

4. Геологийн товч тодорхойлолт.

Манай компани нь 2008 онд “универсальгео”ХХК-тай гэрээ байгуулан, тусгай зөвшөөрлийн нийт 11,4га талбайд нарийвчилсан хайгуул хийлгэн, нөөцийг тогтоолгосон. Хайгуулын ажлыг шнек өрмөөр гүйцэтгэж, геологийн баримтжуулалт, сорьцлолт, нөөцийн тайлан зохиох ажлын “Универсальгео” ХХК, 1:2000-ны масштаб бүхий байр зүйн зураглалыг “Оюусөрвэй” ХХК гүйцэтгэсэн. Хайгуулын шугам хооронд 237-278м, малталт хооронд 97-187м торын нягтралтайгаар хайгуулын 4 шугамын дагуу 8 цооног 5,4-10,8м гүнтэйгээр нийт 69,8т.м өрөмдлөг хийсэн.

5. Ордын уул-геологийн нөхцөл

Ордын геологийн тогтцод эоловийн буюу салхины элсээр хучигдсан дээд плейстоценийн аллювийн, аллюви-пролювийн гаралтай хайргархаг, сайргархаг, шаварлаг хурдас зонхилон, түүний доор орших плиоценийн нуурын гаралтай улаавтар өнгөтэй хурдас тархсан.

2008 онд хийсэн хайгуулаар плиоцений хурдасны плейстоцен, голоценийн давхарга нь 3,6м /ц-6/-ээс 9,0м /ц-8/ хүртэл зузаантай хурдасаар хучигдсан нь тогтоогдсон. Цооногуудын зүсэлтээс үзэхэд

ихэвчлэн улаавтар, шаравтар, саарал, цайвар, саарал өнгийн элсэрхэг, шаварлаг, дайрга-элсэнцэр, элсэнцэр-хайрга хурдсууд байх бөгөөд эдгээрт жижиг хэмхдэсүүд 5-20% агуулагдах ба ховор тохиолдолд 40-60% хүрч байна.Ордын хэмжээнд голоценийн хурдас тархсан байна.

Энэ байдал хайгуулын цооногуудаас авсан сорьцуудыг ФМХШ-ийн үр дүнгээр дээрх чиглэлд 0,14мм-ээс нарийн фракцийн эзлэх хувь өсч байгаагаас харагдана.Элсний ширхэгүүд ирмэгтэй буюу сулхан мөлгөржсөн. Химийн найрлагын хувьд $S;O_2$ 37.44 – 47.92%, K_2O 2.75 – 4.55%, Na_2O 2.7 – 3.54%, $K_2O + Na_2O$ 4.86 – 6.30%, SO_3 0.02 – 0.39% байна. Тусгай зөвшөөрлийн талбайд салхины гаралтай элсний зузаан 3,6м – 8,3 м (ц-2, ц-4) хүрдэг.

6. Нөөцийн тооцоо, хаягдал, ба бохирдолт чанарын үзүүлэлтүүд

Нөөцийн тооцоо: Тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээнд буюу 11,4га талбайд нарийвчилсан хайгуул хийж, 632,7мян.м.куб элсний нөөц тогтоож, батлуулсан. Ашигт давхарга нь салхины гаралтай элснээс бүрдэнэ. Элсний давхаргад /ц-1/ 1,4м зузаантай хайрга-дайрхархаг мэшил хэлбэрийн үеэр бохирдсон хэмжээг итгэлцүүр хэрэглэн давхаргын нийт эзэлхүүнээс хасаж тооцсон байна.

Элсний чанар. 2008 онд өрлөг шавардлагын түүхий эдийн нөөц тогтоохоор хийсэн хайгуулаар цооног бүрээс элсний энгийн дээж 8, дайрга элсний хольцоос 8, цооногуудын дайргархаг-элснээс нэгдсэн 1 дээж авч физик механик шинж чанарыг тодорхойлуулсан.

Эндээс үзэхэд элс нь 0,14-0,3 мм-ийн фракц давамгайлсан жижиг ширхэгтэйд хамаарч эзэлхүүний 65,6-92,1%-ийг эзэлдэг. Ширхэгийн модуль 1,33-1,95 хооронд /ц-7, ц-3/, дунджаар 1,52%, шаварлаг, тоосорхог хэсгийн агуулга 1,8-7,5% хооронд /ц-1/, дунджаар 4,28% байв. Элсний 0,14мм-ээс бага фракцийн эзлэх хувь MNS2803-2004 стандартад заасан 10%-иас ихгүй, шавар тоосны хувь 3%-иас ихгүй байх шаардлагыг В-1, В-2/ц-4, ц-5/ бүрэн хангаж, харин В-3 /ц-7, ц-8/-д 7,0-10,1% болж угаах шаардлагатайг харуулна. Гэвч MNS392-98-д тодруулснаар шавар тоосны хольцзарим нөхцөлд шаардлага хангана.

Лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтууд:

Налайхын элсний ордуудад өмнөх жилүүдэд хийсэн судалгаагаар элсний физик механикийн болон технологийн шинж чанарыг тодорхойлсон байна. Үүнд:

1. Ордын элс нь цемент ба шохойн холимог холбогч хэрэглэсэн нөхцөлд хөнгөн бетон бүтээц үйлдвэрлэхэд тохирно.

2. Бат бөх, ус шингээлт, хүйтэнд тэсвэрлэлтийн үзүүлэлтүүд нь нэр бүхий шаардлага хангасан бүтээцүүдийг гаргаж авахад зохицоно.

3. Барьцалдуулагчаар цемент хэрэглэсэн тохиолдолд том оврын блокууд үйлдвэрлэх шаардлагад нийцнэ.

5. 2 үет хөнгөн бетон блок үйлдвэрлэх


5. Сийрмэг бетоноор армосиликат болон газосиликат бетон бүтээц үйлдвэрлэх боломжтой гэж тогтоож байна.

1. Ашиглалтын технологи

Уг ордын хувьд үржил шимт хөрс болон хар шороон үе дунджаар 0,2м байна. Иймд хөрсний өнгөн хэсгийг утгуурт ачигчаар түрж гүйцэтгэнэ. Хуулсан хөрсийг түрж эхний жилүүдэд тусгай зөвшөөрлийн тайлбайн хязгааруудаар түр хугацаагаар жижиг овоолго болгон байрлуулна. Цаашид уурхайн ашиглалт дууссан талбайд жигд байрлуулна. Энэ нь ашиглалт дууссан хэсгүүдийн нөхөн сэргээлтэд тухай бүр зориулагдах юм. Уурхайн хөрс хуулалтын итгэлцүүр үлэмж бага, ихэнх талбай нь элсээр хучигдсан, бут сөөг, ургамлын тархацгүй, салхины улмаас үүссэн элсэн манхан, өмнө ухаж байсан гүдгэр хонхорцогтой, 2019 онд ашиглах талбай нь хөрс хуулалт байхгүй. Химийн ямар нэг бодис хэрэглэхгүй, тэсэлгээ шаардлагагүй, төлөвлөгөөт онд технологийн ус хэрэглэхгүй.

Уурхайн ашиглалтын гүн их биш, уул геологийн бусад нөхцөл харьцангуй энгийн тул олборлолт, тээвэрлэлтийн системээр ил аргаар олборлоно. В-2 блокоос 3-4м зузаантай элсийг шууд ачиж, хэрэглэгчдэд нийлүүлнэ. Энэ блокийн элс нь жигд нарийн ширхэгтэй тул өрлөг, засвар, өнгөлгөөнд шууд хэрэглэх болмжтой. Харин В-1 блокийг элсэн дэх хайрга, дайрганы хольцийн хувь 20-30% байх тул шигшүүрээр шигшиж, нарийн элст хэсгийг шууд борлуулна.

Элс олборлолтын технологийн схем



2.Технологийн усан хангамжийн эх үүсвэр, хэрэглээ, хаягдал, усны цэвэршүүлэлтийн технологи

Эхний 6-10 жилд ордын дээд хэсэг буюу шаварлаг багатай В-1, В-2 блокуудаас олборлолт явуулна. Цаашид В-2,В-3 блокт 2 үеэр ашиглалт хийнэ.

3. Уурхайн цахилгаан хангамж, түүний схем, эх үүсвэр

2009 онд “Электросеть проект”ХХК-иар уурхайн цахилгаан хангамжийн техник ажлын зургийг хийлгэж,техникийн нөхцлийг 2009 оны 6 сарын 11-нд УБЦТСүлжээ ХК баталсан. Цахилгаан угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Зохих стандартын дагуу хийж гүйцэтгэсэн гэж тусгай комисс 2010 онд хүлээн авсан.

Хоёр. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлолт

2.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Элс олборлох, ачих, шигших явц болон элсний овоолго, автомашины хөдөлгөөнөөр тоос шороо гарч орчны тоосжилтыг нэмэгдүүлж, агаарын чанарт нөлөөлнө.

Мөн хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас тоосжилт, үнэр, утаа тортог нэмэгдэж магадгүй.

-Нөлөөллийн код-агаар

- Хөрс хуулалт
- Элс олборлолт
- Овоолго
- Ачих, тээвэрлэх

Гол эх үүсвэр:

а\ Уурхайн доторх сул элс салхинд хийсэх

б\ Утгуурт ачигч элс хутгах, ачих үед

в\ Автомашины хөдөлгөөнөөс тоосжилт нэмэгдэх

г\ Элсийг шигшүүрийн бункэрт хийх, конвейероор дамжих, ялгалт явагдах, овоолго үүсэх болон овоолгоос ачилт хийх

д\ Энэ оны олборлолт явуулах хэсэгт шимт хөрс, ургамлын давхарга байхгүй, элсэн хучилттай байгаа тул хөрс хуулалттай холбогдон гарах тоосжилт гэж гарахгүй юм. Гэхдээ дагтаршсан элсэн манхан суларч шороо тоос нэмэгдэх магадлалтай.

е\ Хүнд машин механизмын хөдөлгүүрийн утаа, хорт хийх нэмэгдэх

Тархалтын бүс: Уурхай, уурхайгаас төв зам хүртэл, шигшүүрийн ойр орчим

Нөлөөлөлд өртөх объект: Уурхай болон шигшүүр дээр ажиллагсад, жолооч, операторч, агаар орчин, хөрс ургамал

Мөрдөж ажиллах хууль тогтоомж, стандарт:

а\ Агаарын тухай Монгол улсын хууль тогтоомжууд

б\ Агаарын чанарын стандарт MNS 4585:1998

в\ Ажлын байрны агаарын чанар

г\ Олон улсын хүрээлэн байгаа орчны агаарын чанарын удирдамж материал

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ:

Тоос	0.5 мг\м ³
Нүүрстөрөгчийн дутуу эсэл:	5 мг\м ³
Альдегид	0.035-0.5 мг\м ³
SO ₂	0.5 мг\м ³
Ажлын орчны агаар, эрүүл ахуйн шаардлага	

2.2 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Элс олборлох үед химийн бодис хэрэглэхгүй тул ус, хөрс, агаарын орчинд химийн бохирдол үзүүлэхгүй, харин үйл ажиллагааны явцад автомашин, ачигч зэргээс асгарсан тос, тосолгооны материал нь элсэн хөрсөнд шингэн хөрсний ус болон борооны усаар дамжин элсэн давхаргын бохирдол үүсгэх талтай.

Энэ онд үйл ажиллагаагаа 4-10 сарын хооронд 6-7 сар ажиллах бөгөөд 1 автомашин, 1 ачигч байх тул ус, хөрсөнд төдийлөн бохирдол багатай.

Элс олборлолтын эхний жилүүдэд ус ашиглахгүй. Харин ундны болон ахуйн хэрэгцээний усыг гүний худгаас татаж ашиглана. 2010 онд төлөвлөсний дагуу худаг барьж ашиглалтад оруулсан тул уурхайн талбай, зам, тоног төхөөрөмжийн орчныг шаардлагатай үед усалж байх юм.

Элсний уурхайд харьцангуй цөөн тооны ажиллагсадтай байх тул ахуйн хэрэглээний усны хэрэглээ өдөрт 20-30 л байх юм. Иймд ахуйн бохир усыг цэвэршүүлэх асуудал байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, тайланд тусгагдаагүй байна.

Тусгай зөвшөөрөлтэй талбай болон ойр орчимд булаг, шанд, гол горхи байхгүй бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас ойрын жилүүдэд гадаргын усанд хэмжигдэхүйц нөлөө үзүүлэхгүй болно. Харин гүний худгийн усанд хяналт шинжилгээ хийгдэх болно.

Үргэлжлэх хугацаа: төлөвлөгөөт оны турш

2.2.1 Усны орчны стандарт ба норм

а\ Гадаргын усны чанарын стандарт

б\ Усны чанарын стандарт MNS4586: 98
в\ Ундны усны стандарт MNS900 :2005
г\ Усны чанар, хаягдал бохир ус MNS4943 :2000
д\ Бохирдлоос урьдчилан сэргийлэх гарын авлага WBG

2.3 Хөрсний чанарт нөлөөлөх нөлөөлөл

Уурхайн олборлолт, шигшүүрийн үйл ажиллагаа, ажиллагсадын байр, сууц, хүнд даацын техникийн хөдөлгөөн, цаашид ургамалжсан хэсгийг хуулах, овоолго хийх, шигшсэн элсний овоолго, бохир хайрга ялгах, цаашид элс угаах үйл ажиллагаанаас хамааран орчны газар эвдрэлд орж, одоо байгаа төрхөө алдах юм.

Зөвшөөрөлтэй талбайд ургамалжсан талбай харьцангуй бага бөгөөд ихэнх талбай \70 орчим хувь\ нь элс, элсэн манханаар хучигдсан. Эхний 5 жилд хөрстэй \алаг цоог ургамалжсан\ хэсэгт үйл ажиллагаа явуулахгүй тул энэ онд хөрс хуулалтын талаар арга хэмжээ тусгагдаагүй.

Харин автомашины хөдөлгөөнөөс хөрсөн бүрхэвч эвдрэх магадлалтай.

Нөлөөллийн шинж чанар: Элс олборлолтын талбайн хэмжээнд хөрсөн бүрхэвч хуулагдаж, газрын хэвлийд хонхор, газрын гадарга дээр хаягдал үүсэх, шаварлаг элс чулуулгийн болон хөрслөг хэсгийн овоолго бий болж, газрын ландшафтын өөрчлөлт бий болно.

Хүнд машин механизмын зогсоол, шатах тослох материалын агуулах, ажиллагсадын сууц зэрэг газар бохирдолтод өртөх талтай.

Автомашин, ачигч зэргийг түлшээр цэнэглэх, тосолгоо үйлчилгээ хийх, шатах тослох материал асгарах, засвар хийх явцад газрын хөрс бохирдоно. Энэ нөхцөлд бохирдсон хэсгийг хуулж авч, цэвэрлэгээ хийх, бохирдсон хэсгийг зохих журмын дагуу нөлөөлөлгүй болгох, тусгай зөвшөөрөгдсөн хэсэгт булах г.м арга хэмжээ авна.

Нөлөөллийн эх үүсвэр: Уурхайн олборлолт, хүнд машин механизмын хөдөлгөөн.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа: Элс олборлох үйл ажиллагаа ТЭЗҮ-д тусгаснаар 17 жил байх боловч энэхүү төлөвлөгөөний хамрах хүрээ 6 сарын хугацаатай байна.

Нөлөөлөлд өртөх зүйл: Уурхайн орчны хөрс, ургамал, амьтан

2.3.1 Байгаль орчны стандарт норм

Нөхөн сэргээлт хийхэд мөрдөх стандартууд:

- а\ MNS 5914: 2008 –Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх шаардлага
- б\ MNS 5915: 2008- Уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын ангилал
- в\ MNS 5916 :2008-Үржил шимт хөрсийг хуулах ба түр хадгалах журам
- г\ MNS 5917: 2008- Уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын ерөнхий ангилал
- д\ MNS 5918 :2008- Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн шаардлага

2.4. Ургамал, амьтанд үзүүлэх нөлөөлөл

Элс олборлолтын үйл ажиллагаатай холбогдон уурхайн эдэлбэр газрын 30 орчим хувьд ургамлын бүрхэвч эвдрэх юм. Харин энэ оны хувьд хөрс хуулалт байхгүй, шууд элсэн манхан болон элсэн бүрхэвчтэй хэсгээс олборлолт явуулна. Тусгай зөвшөөрөлтэй талбайн хүрээнд ховор, нэн ховор ургамал, амьтан төдийгүй элбэг тархалттай хулгана, зурам г.м. ч ажиглагдаагүй болно.

Нөлөөллийн эх үүсвэр: Уурхайн талбай, машин механизм явах зам харгуй

Байгаль орчны хууль ба стандартууд: Ургамал ба амьтны тухай хууль

Нөлөөллийг арилгах болон бууруулах арга зам: Ургамал нь устгагдах талбайн ургамлыг олборлолт дууссаны дараа буюу ашиглалт дууссан талбайгаас эхлэн сэргээх үйл ажиллагаа явуулах болно. Элс олборлож дууссан талбайд үржил шимт хөрсөөр хучих, элсэн хөрсөнд ургах чадвартай олон наст ургамлын үр цацах зэрэг нөхөн сэргээх арга хэмжээ авна.

Хэрэгжилт:

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний төслийн биелэлтийг **хүснэгт №1-д** харуулав. 2022 онд арга хэмжээг хэрэгжүүлэхэд 4499,0 мянган төгрөгийн зардал гарсан болно.

Гурав. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ

2022 онд нөхөн сэргээлтийн арга хэмжээнд 3540,0 мянган төгрөгийн зардал гарсан. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийг **хүснэгт №2-д** харуулсан. Мөн уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн 2022 оны мэдээг БОХ-3 маягтаар гаргаж хавсаргав.

Дөрөв. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг орон нутгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний 2022 оны биелэлтийг **хүснэгт № 3-аас** үзнэ үү.

Тав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, энэхүү төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, уурхайн удирдлага, ажиллагсадад байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалтын арга барил эзэмшүүлэх, хариуцлага тогтоох механизм бий болгох арга хэмжээ авч ажиллаж байна. Үүнтэй холбогдон гарах зардлыг жил бүр төлөвлөж байна. Тухайлбал:

-аюул ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө

-байгаль хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээ

-гал, түймэр, цахилгааны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

-байгаль орчны төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлыг хариуцан ажиллах ажлын байрны тодорхойлолт гарган ажиллаж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний **биелэлтийг хүснэгт № 4-д** харуулав.

Зургаа. БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах, хог хаягдлын менежмент

Хүснэгт № 5, 6-д байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх болон хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 2022 оны биелэлтийг тус тус харууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Нийт зардал
НЭГ. АГААР МАНДАЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ								
	ТООСЖИЛТ БОЛОН БОХИРДУУЛАГЧ ХИЙН НӨЛӨӨГӨӨР ОРЧНЫ АГААР БОХИРДОХ	Уурхайн зам, талбай, шигшүүрийн орчны усалгааны хэмжээ, горимыг сар улирлаар оновчтой тогтоох	Ашиглалтын талбай, хөдөлгөөнт хэсэг/2 га/	хавар, намрын хуурай үед, 7 хоног, сараар	БОС-ын 1995 оны 153 тоот тушаал	хаврын болон намрын хуурай үед услах	4, 5 сард долоо хоног тутамд зам уурхайн талбайг 5 удаа усалсан.	Зардал/ үс, цахилгаан, цалин/ 18000 х 5= 90.0 м/төг. ҮА-ны зардалд
		Уурхайд орж гарах машин, ачилт хийх, шигших хоорондын зайг тоосны сарнилттай үялдуулах	Ашиглалтын талбайд	Ашиглалт явуулах хугацаанд	MNS5885: 2008	Ачаалал ихтэй үед	Энэ онд өдөрт 0-2 машинд ачилт хийж , ачаалал бага	Зардал тооцоогүй
		Хүнд машин, механизмын утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлж байх	Хүнд даацын авто машин, ковш	жилд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ	Оношлогоод хамруулах, засвар үйлчилгээ цаг тухай бүр хийх	Оношлогоон д 1 машин, засвар, үйлчилгээ тос, тосолгоог байнга хийв.	Зардал: ҮА-ны зардалд 2,6 сая төгрөг туссан.
		Элс ачсаны дараа машинаа бүтээлгээр бүтэн хүчиж байхыг өөрийн болон гадны машины жолооч,	Элс ачсан машинд	тухай бүр		Хуучин урагдсан бүтээлгээ солих	2 бүтээлэг худалдаж авсан, элс ачсаны дараа хучих	Зардал: ҮА-ны зардалд 160,0 мян.төг орсон.

		операторт хэвшүүлэх,					ажлыг хэвшүүлж байна.	
		Сул зогсолтын үед том оврын автомашин, ковшийг асаалттай байлгахыг хязгаарлах	ХОВО машин, ковш	байнга			хяналт тавьж, жолооч нарт байнга анхааруулж байгаа	зардал гарахгүй арга хэмжээ
		Ажилчдыг тоосноос эрүүл мэндээ хамгаалах хэрэгсэл, хүнсээр хангах, сургалт, зөвлөлгөө өгөх	төслийн хэмжээнд			Тоосноос хамгаалах хэрэгсэл авах	Маск 7 ш авсан	ҮА-ны зардалд 14,0 мянган төгрөг туссан
		Автомашин техникийн кабины бүрэн бүтэн байдал, тоос нэвтрүүлж байгаа эсэхийг хянах	төслийн хэмжээнд	тухай бүр			кабины бүрэн бүтэн байдлыг хянаж үзсэн	зардал гараагүй
ХОЁР.ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАДАРГЫН ХЭЛБЭР ТӨРХӨНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ								
		Шимт хөрсний овоолго хийх, хадгалах, хамгаалах	ашиглалтын талбайд	хөрстэй хэсэгт олборлолт хийх үед	MNS5915: 2008	БЛОК-1 д орох үед	БЛОК-1-д ороогүй тул хөрс хуулалт хийгдээгүй	зардал гараагүй
		Уурхайн орох гарах болон кемп орчмын замыг сайжруулах, олон салаа зам гаргахаас сэргийлж тэмдэгжүүлэх, ажилчдад зөвлөлгөө өгөх	кемп орчимд	хавар ажил эхлэхээс өмнө болон 5-р сард	шороон зам сайжруулах шаардлага	уурхайд орох гарах болон кемпийн доторхи зам	кемпийн урьд болон уурхайн амруу орох замын хэсгийг том ширхэгт хайргаар сайжруулсан 2 ширхэг	зардал: ҮА-ны зардалд орсон. 2 тэмдэг - 224,0 мян. төгрөг, бусад зардал жишиг нормоор

							замын тэмдэг байршуулав	тооцоход 224,0 мянган төгрөг
		Олон салаа зам гарахаас сэргийлж нэмж хашаа татах/ тоосжилт, хөрс бохирдохоос сэргийлэх	кемп орох хэсэгт	4-р сард		хаалга орчимд хийх	хаалга гаргаж, 50 м хашаа татав. Кетп шилжүүлж, хөрс цэвэрлэж, хог зайлуулав. 4-р сард	800,0 мянган төгрөг
		Засмал замаас кемп орох замын арчилгаа/хөрс, гадаргад нөлөөлөх байдлыг багасгах/	30м	6-р сард		30м	тэгшилгээ хийж, хайргаар тагтаршуу- лав. 30м замд	ковш, машины шатахууны тооцоогоор 40,0 мянган төгрөг
		Шатах , тослох материалыг хадгалах байрыг сайжруулах	төслийн хүрээнд	жилд		Хадгалах сав шинээр авах	Блокоор тусгай байр барьж, ШТМ болон нүүрс, түлээ хадгалах өрөөтэй	0,2 сая төгрөг/ ҮА- ны зардалд/
		Шатах, тослох материалын хадгалалтыг сайжруулж, асгарч хөрс бохирдуулахаас хамгаалах					шинээр 1 ш шатахуун, тос, тослох материал хадгалах сав-40л	20,0 мянган төгрөг /ҮА-ны зардлаар/

		Байгаль орчныг хамгаалах талаар ажилчдад зөвлөлгөө өгөх	ажилчдад	жилд		2 удаа	Хууль, дүрмийг танилцуулж, чиглэл өгч ирсэн. 2-3 удаа	Зардал тооцоогүй
	ХӨРС ЭЛЭГДЭЛ ГЭМТЭЛД ОРОХ, ҮРЖИЛ ШИМ, ЧИЙГ БУУРАХ БОХИРДОХ, ГАДАРГЫН УНАГАН ХЭЛБЭР ӨӨРЧЛӨГДӨХ	Кемпийн орчинд том оврын автомашины хурдыг бууруулах арга хэмжээ авах	Уурхай орох зам	5-р сард		тэмдэг тавих	хурдны хязгаарыг 5 км/цаг гэсэн тэмдэг	15,0 мян.төгрөг
		Автомашин, ковш зэрэг техникийн засвар үйлчилгээг нэг цэгт хийх замаар тос, шатахуун асгаж, хөрс бохирдуулахаас хамгаалах	Кемп орчинд	7-р сард		хашаан дотор цэг байгуулах	Нэг цэгт хийхээр зааж, талбай зассан.	Зардал тооцоогүй
		Сэлбэг хэрэгслэлийг тусгай байранд хадгалах замаар хөрс бохирдуулахаас хамгаалах	Ажилчдын байрны хашаанд	6-р сард		Хуучин байрыг засах, тавиур хийх	Байрыг засаж, 1 ш тавиур хийв.	Гарын дор материал ашигласан
		Хөрсний шинжилгээ хийлгэх	уурхайн ойр орчимд			ерөнхий шинжилгээ	Химийн шинжилгээ хийлгэсэн.	90,0 мянган төгрөг
		Газар ашигласны төлбөрийг тухай бүр төсөвт төвлөрүүлэх	Төслийн хүрээнд	тухай бүр		ҮА-зардлын төлөвлөгөөнд тусгах	Хугацаанд нь төлсөн	хүлээгдэж буй
ГУРАВ. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ								
		Унд ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс тогтоох	Кемп орчинд	жилд		Хамгаалалтын бүс тогтоох	Худгийг тойруулан хашааг сэргээн засвар хийж,	ҮА-ны зардалд оруулсан.

							тоолуур тавьсан.	
	УСНЫ НӨӨЦИЙН ГОРИМЫН ӨӨРЧЛӨЛТ	Ус ашигласны төлбөр төлөх, шинжилгээ хийлгэх				ҮА-д тусган төлбөр төлөх		100,0 мян. төг.
		Ахуйн бохир усыг тусгай цооногт хуримтлуулах, бохирдлыг саармагжуулах, ариутгал хийх	Уурхайн орчимд, төслийн хүрээнд	Жилд 2 удаа	MNS4943: 2011	Ариутгал хийх	2 удаа ариутгал хийсэн, 2-3 хүний хэрэгцээ- жилдээ 1,5 тн	Зардал: 50,0 мянган төгрөг
		ОО-ын байгууламжийн ариутгал	Кемпээс 70 м	Жилдээ 2 удаа		Ариутгал хийх	2 удаа ариутгал хийсэн. Эко жорлон	80,0 мянган төгрөг
ДӨРӨВ. УРГАМАЛ, АМЬТАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ								
	УРГАМАЛ, АМЬТАН ХОВОРДОХ	Уурхайн эдэлбэр газрын хязгаараар мод тарих, зурваст олон наст ургамлын үр цацах замаар ургамлын нөмрөг үүсгэх	Хашаа татсан хэсэгт	Хавар, зун бороо орсны дараа		0,02 га-д	0,03 га-д олон настын үр цацсан	16,0 мянган төгрөг
		Уурхайн орчимд зэрлэг ургамал ургахаас сэргийлэх	төслийн хүрээнд	байнга		тусгаагүй	Ахуйн бохирдол, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх	зардал гараагүй
		Аянга, цахилгаанд амьтад өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	төслийн хүрээнд	байнга		Хянан шалгалт хийх	Газардуулга, цахилгааны утасны бүрэн бүтэн	Зардал гараагүй

							байдал, трансформаторын орчинд хяналт шалгалт хийв.	
		Уурхайн орчинд орж гарч байгаа амьтан шувуудын ажиглалт хийх, тэдгээрийн хөдөлгөөний талаар тэмдэглэл хөтлөх	Төслийн хүрээнд	Байнга		Ажиглалт явуулах, намар чацаргана ургасан үед их хэмжээний шувуу ирдэг	Өвлийн улиралд туулай ганц нэгээр, харин болжмор үе үе үзэгдэж байгаа	Зардал тооцоогүй
		Элс, хайргархаг хөрсөнд тариалж болох мод, бут сөөг, тариалах технологийн талаар судалгаа явуулах	Төслийн хүрээнд	сургалт явуулах		2022 онд тусгаагүй	Мод, жимс ногоо хүлэмжид тариалах сургалтад хамрагдав.	Зардлаа хувиасаа гаргасан.
		Элсэрхэг газар ургах магадлал өндөртэй мод, бут сөөгийн суулгацыг хүлэмжид тариалах туршилт хийх	Төслийн хүрээнд эвдэрсэн газар мод, бут сөөг тариалах	Жил бүр		2018 онд бургас суулгажтуршилт явуулах	85 ш бургас, чацаргана суулгав	Зардал тусдаа тооцогдсон
ТАВ. ЭРҮҮЛ АХУЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ								
		Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах	Төслийн хүрээнд	Жилд 1 удаа	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны журам	2021 онд 2 хүн хамруулах	4 ажилтан хамрагдсан	1000,0 мянган төгрөг

АЖИЛЛАГСАДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ	Ахуйн нөхцөлд үзлэг хийж, сайжруулж байх	Ажилчдын амьдрах, амрах, хооллох байр	Жилд, байнга		Үзлэг хийх, хяналт тавих	Байрны цэвэрлэгээг сайжруулах, аяга таваг гэх мэт шинэчлэх, усанд орох өрөөний усны насос солив.	270,0 мянган төгрөг
	Сүү, сүүн бүтээгдэхүүн, элчлэг хоолны норм хэмжээг хянан үзэж, нэмэгдүүлэх, уурхайн дэргэд тарьсан чацарганы шүүсээр хангах	Нийт ажиллагсад	Байнга	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны журам	хянан үзэх	7 хоногт хэрэглэх сүү, тарагны хэмжээг нэмсэн, халуун хоол өдөрт 3 удаа	ҮА-ны зардалд нэмэгдсэн
	Ажлын хувцас, хамгаалалтын бүс, чихэвч, хошуувч зэргээр хангах	Ажилчид	Ажлын хувцас 2 жилд 1 удаа, чихэвч, хошуувч тухай бүр	Аюулгүй ажиллагааны хууль, журам	300,0 мянган төгрөг төлөвлөсөн	Ажилчдын тоо буурсан тул 200,0 мянган төгрөгийн зүйл авсан.	200,0 мянган төгрөг
	НИЙТ ДҮН, мянган төгрөг, үүнээс шууд зардал						5969,0 4499.0

Захирал

Ш.Энхзаяа

2022 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

БИЕЛЭЛТ

№	БАЙРШИЛ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗАРДАЛ, МЯНГАН ТӨГРӨГ
		НЭР	СТАНДАРТ, АРГАЧЛАЛ, НОРМ			
	НЭГ. ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ					
	1,2-р блок, мөргөцөг Цэг 3	Налуу гаргах	MNS5915:2008	400 м ² /20 X20/	700 м ² 20м X 35м Зураг үзнэ үү.	1300,0 мянган төгрөг /эксковатор түрээсээр/
	ХОЁР. БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ					
	1-р блок, ашигласан талбайд	мод худалдан авах	Мод тарих аргачлал	100 ширхэг	100 ширхэг чацаргана	500,0 мянган төгрөг /100х5000 төг/
	Уурхайд	Олон наст ургамлын үр авах	Гарын авлага, MNS5914:2008	20 кг	5 кг, Канад сортын согоо бор, зүлэгний холимог	180,0 мянган төгрөг
	Уурхайн төсөлд	Хар шороо худалдан авах		18 м ³	16 м ³	400,0 мянган төгрөг
	1-р блок налууд	мод суулгах / өтгө бууц бэлтгэх гм/	Гарын авлага	12	16	60,0 мян. төг.

	Уурхайн төсөлд	Мод суулгах	Аргачлал	100 ширхэг	100 ширхэг	600,0 мянган төгрөг /нүх ухах,суулгах, 100ш X 6000 төг/
	Уурхайн хүлэмжинд	Ажилчдын хэрэгцээнд хүнсний ногоо тарих	Гарын авлага, сургалт	Өргөст хэмх, улаан лооль, хүрэн манжин, хулуу, сонгино	Өргөст хэмх, улаан лооль, манжингийн суулгац авахад	зардал тооцоогүй
	Уурхайд	Мод тарих хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх зорилгоор		модны нүх ухагч худалдаж авах	Модны нүх ухагчийн сэлбэг, шатахуун	бусад зардалд
	Уурхайд	Мод ургамлын арчилгаа	Аргачлал	тухай бүр	Усалгаа, сэлгээ, тогоо сэргээх гэх мэт	500,0 мянган төгрөг
	ДҮН			4500		3540,0

Захирал

Ш.Энхзаяа

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ЗОРИЛТ	ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭ	БАРИМТЛАХ СТАНДАРТ, АРГАЧЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	
					БИЕЛЭЛТ	ЗАРДАЛ
УРГАМАЛ УСТАХ, ӨСӨЛТ УРГАЛТ НЬ СААРАХ, ТӨРӨЛ ЗҮЙЛ ӨӨРЧЛӨГДӨХ, БИОМАСС БАГАСГАХААС ХАМГААЛАХ	Ургамал устах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц багасахаас хамгаалах, хяналт тавих	Ашиглалтын талбай болон зам дагуу тарьсан мод, хөрсний орчинд хяналт тавих	Байгалийн ургамлын тухай хуулийн 7-р зүйл	Мод, хөрсний тогтоцод хяналт тавьж, авах арга хэмжээг боловсруулах	Нийт 1100 мод тарьснаас 75% - тай байна. Цаашид хар шороон хөрс тогтоож, олон наст ургамал нэмж тарих.	Зардал тооцоогүй
	Ургамлын нөмрөг нь нөлөөлөлд өртөхгүй талбайг хамгаалалтад авах, хяналт тавих	Ашиглалтын талбайн гадна төв зам дагуу татсан 800 м урт хашааны талбай		Хашааг сэлбэн засах, мод, ургамлын хөрс тогтолтод анхаарах	Хашааг жил бүр сэлбэн засч, мод , ургамлыг хуурайшилтай улиралд услах арга хэмжээ авсан	Мод услах, хашаа сэлбэхэд 100.0 орчим мянан төг.
	Орон нутгийн удирдлагатай тохирсон газарт хөрс хамгаалах, дүйцүүлэн хамгаалах тохиромжтой газар сонгох	Налайх дүүргийн нутаг дэвсгэрт	БОХ тухай хуулийн 31-р зүйл		Нийслэл орчмын ойн зурвасын цахилгаан шугам татахад	900,0 мянган төгрөг

	Орон нутагт тохижилт, зүлэгжүүлэлт хийх	Налайх дүүргийн 5-р хорооны төв хэсэгт		Хорооны тохижилт, зүлэгжүүлэлтэд оролцох	Зам талбай засаж орчны бохирдлыг арилгах ажилд 5 машин элс, хайрга нийлүүлсэн.	1200,0 мян. т
	Орон нутагт зам талбай тохижуулах	Налайх дүүрэг			Дүүргийн онцгой байдлын албанд 5 машин элс, хайрга	1400,0 мянган төгрөг
	Биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар ажилчдад зөвлөлгөө сургалт явуулах	Нийт ажиллагсад		Зөвлөлгөө өгөх	Зөвлөлгөө өгч, хэвшил болгож байна,	Зардал тооцоогүй
	ЗАРДЛЫН ДҮН		2000,0 м/төг			3600,0

Захирал

Ш.Энхзаяа

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2022 ОНЫ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хугацаа	Төлөвлөгөө, зорилго	Биелэгдсэн байдал	Зардал, мянган төгрөг
1	НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
2	Байгаль орчны асуудлыг нэг мэргэжилтэнд хариуцуулж, захирал хяналт тавин ажиллах	Захирал	4-р сард	Байгаль орчны холбогдох хууль, журмыг мөрдүүлэх	Байгаль орчны асуудлыг хариуцсан ажилтан ажиллуулсан	Цалин: 500,0
3	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолт гаргаж мөрдүүлэх	Захирал	5-р сард	Хийх ажлыг тодорхой болгож, хариуцлагажуулах, хяналт тавих	Ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж, мөрдөн ажиллуулж байна.	-
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох байгууллагаар батлуулах	Хариуцсан ажилтан	10-р сар, 2-р сар сард	БОМТ төлөвлөгөө, гүйцэтгэл гаргах, хянуулах	БОМТ-ын урьд оны гүйцэтгэлийг хугацаанд нь гаргаж тайлагнасан. Ажлын чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авч байна.	Кадастын зураглал хийх зардал: 500,0
5	Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөг бууруулах, нөхөн сэргээх ажлыг чанартай хийлгэх боломж бүрдүүлэх	Менежер	5,10-р сард	Машин, техник, ковш зэргийг хуваарийн дагуу ашиглуулах	Техникийн нөхөн сэргээлт хийхэд ковшийн цагийн хуваарийн дагуу ажиллуулах, өтөг бууц, хар шороог хангалттай хэмжээнд бэлдэж өгсөн.	Зардал нь тусгай ангилалд туссан.

6	Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг уялдуулах	Хариуцсан ажилтан	Байнга	Ашиглалтын талбайн маневралтын зайтай уялдуулан техникийн нөхөн сэргээлтийн зөв сонголт хийх	Тухайн жилд хийх уулын ажлын явцтай уялдуулан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн зохистой харьцааг тогтоон ажилласан.	-
7	Мод, ургамал тарих, тэдгээрийн арчилгаа сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх шинэ техник, технологи нэвтрүүлэх судалгаа хийх	Хариуцсан ажилтан	Байнга	Мод, талбай услах хөдөлгөөнт ёмкостиг засварлах, усны хоолой, модны нүх ухагч авах зардлыг тооцож хэрэгжүүлэх	Хөдөлгөөнт ёмкостиг ковшоор зөөх шийдлийг тогтоож, нүх ухагч худалдан авч, бүтээмж нэмэгдүүлсэн.	
8	Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Менежер	Тухай бүр	Мод, ургамал услах хуваарийг гаргаж мөрдүүлэх, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх хугацаа, тухай бүр гүйцэтгэх ажлын хэмжээг тогтоох	Мод, ургамлыг хавар, намар болон хуурайшилтай үед услах, арчлах, нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажлын явцтай уялдуулан тогтоож байна.	-
9	Байгаль орчныг хамгаалах, хийх ажлын талаар ажилчдын дунд нөхөрсөг яриа өрнүүлэн тэдний санаа оноог сонсох, олон нийт /гадны жолооч нар гэх мэт/, мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүдийн зөвлөлгөө, санааг асууж, тусгаж байх	Бүх ажиллагсад	Тухай бүр	Зөв санаа оноог тусган хэрэгжүүлэх, ажлаа сайжруулах	Энэ ажлыг хэвшил болгосон. Ажилчдаас хүлэмж барих санал гаргасныг хүлээн авч, 2,9 сая төгрөгөөр худалдан авч, барьсан нь ач тусаа өгч байна.	-

10	Байгаль орчинд ээлтэй байх ухамсар, хүмүүжил олгох талаар талаар ярилцлага, сургалт явуулж байх	БО-ны ажилтан	Жилд 2-оос доошгүй удаа	Байгаль орчныг санамсаргүй бохирдуулахаас сэргийлэх	Байгаль орчныг хамгаалах талаар гарсан мэдээ мэдээллийг ярьж , хэлэлцүүлэг явуулж байна.	-
11	Байгаль орчны ажилтны ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах арга хэмжээ авах	Захирал	Жилд	Ажилчдад зөвлөлгөө өгөх	Холбогдох хууль, журам, стандартыг судлуулж байна.	-
12	Менежментийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хийж гүйцэтгэхэд санал, санаачлагатай оролцсон ажилтнуудыг урамшуулах, шагнах	Компанийн захирал	жилд	Ажлын гүйцэтгэлийг сайжруулах	2 хүнийг 100,0, 100,0 мянган төгрөгөөр шагнав. Цаашид хэвшил болгох нь үр дүнтэй гэж үзэж байна.	200,0
13	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүнг холбогдох эрх бүхий байгууллагад, орон нутгийн хурал, захиргааны байгууллагад танилцуулж байх	Захирал	Хуваарийн дагуу	Хамтран ажиллах арга хэмжээ боловсруулах	Налай дүүргийн 5-р хороонд 9-р сарын 20-нд танилцуулж, ИНХ-аар хэлэлцүүлсэн	-
14	ХОЁР. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
15	Уурхайн үйл ажиллагаа бүрийн технологийн заавар, горим, стандарт, аюулгүй ажиллагааны заавар, дүрмийг ажиллагсадад эзэмшүүлэх	Захирал	Байнга	Шинэ ажилтанд тухай бүр танилцуулах	Зурагт самбар, үйл ажиллагааг харуулсан зураглал амралтын өрөөнд байрлуулан шинэчлэв.	90,0
16	Байгаль хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам батлан	Захирал	Байнга	Ажиллагсадад танилцуулах	Дүрэм боловсруулсан	-

	мөрдөх					
17	Аюул, ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг мөрдөх	Менежер	Байнга	Шинэ ажилчдад танилцуулан мөрдөх	Шинэ ажилчдад танилцуулдаг	-
18	Аваарь устгах төлөвлөгөө мөрдөх	Менежер	Байнга	Шинэ ажилчдад танилцуулан мөрдөх	Төлөвлөгөө батлан, ажилчдад танилцуулсан	-
19	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаар авах арга хэмжээ	Захирал	Тухай бүр	Эмнэлэгийн үзлэгт хамруулах, ажлын хувцасаар хангах	Ажилчдыг эмнэлэгийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулсан, ажлын хувцасыг нормын дагуу олгож байна.	Зардлыг тусгай ангилалд оруулсан
	ДҮН					1290,0

Захирал Ш.Энхзаяа

БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОМТ-г хэлэлцүүлэх байгууллага, арга хэмжээ		Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах хэлбэр	Зохион байгуулах газар	Гүйцэтгэл	Ззардал, мянган төгрөг
1	Налайх дүүрэг	ИТХ Хорооны ИНХ	Хуралд танилцуулах	БОМТ-ийн тайлан	11- сар	Хамтран ажиллах	5-р хорооны байр	2022 оны 11-р сарын 1-нд хэлэлцүүлнэ.	-
2	Төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, байгууллагын оролцоог хангах, тэдэнд мэдээлэл өгөх, санал бодлыг тусгах		Танилцуулга	Мэдээлэл өгөх	Жилд	Хамтран ажиллах	Айл, өрх, байгууллага	Мэдээлэл бэлтгэж, санал авах арга хэмжээ явуулж байна.	-
3	Төслийн эдийн засгийн ач холбогдол, сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээний талаар танилцуулга , хуудас материал бэлдэж тараах		иргэдэд	мэдээлэл өгөх	тухай бүр	Санал авах	айл, өрхөөр	Товч танилцуулга гаргасан. Хүмүүст өгч байгаа	70,0
4									
			ДҮН						70,0

Захирал

Ш.Энхзаяа

ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

	ХОГ, ХАЯГДЛЫН НЭР, ТӨРӨЛ	ХЭМЖИХ НЭГЖ	ТӨЛӨВЛӨГӨӨ			БИЕЛЭЛТ		
			ТОО, ХЭМЖЭЭ	АВАХ АРГА ХЭМЖЭЭ	ЗАРДАЛ	ТОО, ХЭМЖЭЭ	АВСАН АРГА ХЭМЖЭЭ	ЗАРДАЛ
	А.ҮЙЛДВЭРИЙН ХОГ, ХАЯГДАЛ							
	Химийн бодис	кг, литр		байхгүй			байхгүй	
	Шатах, тослох материалын хаягдал	тонн	0,2	тусгай саванд хадгалах, зах зээлд борлуулах		0,3	Тусгай саванд хадгалж, боловс-х байгууллагад өгсөн.	
	Тэслэх, дэлбэрэх бодис	кг		хамааралгүй			хамааралгүй	
	Ашиглалтаас гарсан сэлбэг, дугуй гэх мэт	тонн	0,4	Хогийн цэгт	20,0 м/т	0,5	Төмрийн үйлдвэр, резин, хуванцарын үйлдвэрт өгсөн	
	Аюултай хог, хаягдал	кг, л, ш		гарахгүй			гарахгүй	
	Б. АХУЙН ХОГ, ХАЯГДАЛ							
	Хуурай хог хаягдал	кг	150,0	хогийн цэгт	20,0	160	тухай бүр бага багаар хуримтлуулан хогийн цэгт	70,0
	Шингэн хог хаягдал	литр	800	шингэний цооногт	-	800	Гарсан тухай бүр өөрийн шингэний цооногт хуримтлуулдаг	
	ДҮН				40,0			70,0

Захирал

Ш.Энхзаяа

Долоо.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

БОХ Арга хэмжээ	Хамрах хүрээ	х/н	Тоо хэм- жээ	Нэг- жийн үнэ	Нийт зардал, сая төг	Хэрэг- жүүлэгч	Хамтран хэрэг- жүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1 Гал, үер усны аюул	Уурхайн Т орчинд				5,6	Уурхайн дарга	НОБАлба Утас:702331 33		АА-ны дүрэм
	Г							ГАРААГҮЙ	
	Х							100	
2 Хар салхи, шуурганы аюул	Уурхайн Т орчинд				5,6	Уурхайн дарга	НОБ алба		АА-ны дүрэм
	Г							ГАРААГҮЙ	
	Х							100	
3 Засгийн газрын шийдвэрээр тусгай хамгаалалтад авах	уурхай Т				500,0	Компанийн захирал	Засгийн газар		
	Г							ГАРААГҮЙ	
	Х							100	
4 Химийн хорт бодисын аюул занал үүсэх	Тухайн нутаг Т дэвсгэрт				5,6	Уурхайн дарга	НОБАлба		МУ –н хууль
	Г							ГАРААГҮЙ	
	Х							100	
5 Газар хөдлөх, аянга буух	уурхайд Т				5,6	Уурхайн дарга	НОБАлба		
	Г							Гараагүй	
	Х							100	
6 Мөргөцөг доголын нуралт үүсэх	уурхайд Т				1,0	менежер	-	Нуралтыг арилгах	Ил уурхайн АА дүрэм

	Г	Гараагүй			
	X	100			
7 Гоц халдварт өвчин тахал гарвал	Уурхай, ойр	5,0	менежер	НОБАлба	
	T орчимд				
	гүйцэтгэл			Гараагүй	
	X			100	

Найм.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

БОХ Арга хэмжээ	Хамрах хүрээ	х/н	Тоо хэм- жээ	Нэг- жийн үнэ	Нийт зардал, сая төг	Хэрэг- жүүлэгч	Хамтран хэрэг- жүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1 Түүх, соёлын өвтэй холбогдох зүйл олдвол дараах арга хэмжээ авна:	T					захирал		ТСӨХ хууль	тухай
	Г					олдоогүй			
	X								
1 Уурхайн үйл ажиллагааг зогсоох , 1	Ашиглалт					Захирал,			
	T явуулж буй хэсэгт					уурхайн дарга			
	Г							ГАРААГҮЙ	
	X								
1 Түүх, соёлын зүйлийг хамгаалалтад авах , 2	Уурхайн				0,2	захирал			
	T хэмжээнд								
	Г							ГАРААГҮЙ	
	X								

1 , 3	Хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх	Захирал	
		Т	
		Г	ГАРААГҮЙ
		X	
1 , 4	Түүх, соёлын өвийг хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх	0,2 захирал	
		Г	ГАРААГҮЙ
		X	
Дүн		0,4	
		Г	
		X	100 100

Ес.Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
/Тэсэрч, дэлбэрэх бодис хэрэглэдэггүй болно/

БОХ Арга хэмжээ	Хамрах хүрээ	х/н	Тоо хэм- жээ	Нэг- жийн үнэ	Нийт зардал, сая төг	Хэрэг- жүүлэгч	Хамтран хэрэг- жүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1 Өөрийн болон гадны машин техникээс шатахуун, тос гоожихоос сэргийлэх арга хэмжээ:	Ажилчдын							Дотоод	БОХ хууль
	Т байр, уурхайд							хяналтаар гарсан дүгнэлтээр	
	Г								
	Х								
1, Өөрийн машин, техникийн бүрэн бүтэн 1 байдлыг хангах	уурхайд	ш	4		0,5	механик		Ажиглалт,	
	Т							хяналт	
	Г Уурхайн	ш	4		0,7	механик		Засвар, зардал	
	Х		100		140			110	
1, Техникийн засвар, үйлчилгээг тусгай 2 талбайд хийх	Хөдлөх		4		0,3	Механик,		Тусгай	
	Т техник	ш				оператор		талбайн бэлэн байдал	
	Г Хөдлөх	ш	4		0,3	Механик,		Бетонон	
	техник					орератор		талбай	
	Х		100		100			100	
1, Шатах, тослох материалыг тусгай 3 байранд хадгалах	Агуулах сав	ш	1	0,3	0,3	Оператор,		Байр бэлдсэн	
	Т					механик		байдал	
	Г агуулах	ш	1		0,2	механик		1 сав авав	

	X	100	66	83
1, 4 Шатах, тослох материал хадгалах орчны цэвэрлэгээ хийж байх	T		0,1	цэвэрлэгч
	Г	Хадгалах орчинд	0,1	цэвэрлэгч Цэвэрлэгээ материал
	X		100	80
1, 5 Автотехникийн сул асаалтыг аль болох багасгах	T			Механик, оператор
	Г	Тосгон орчимд		Механик, оператор хэвшив
	X			90
1, 6 Техникийн ажилчдад байнга анхааруулж байх	T			механик
	Г			механик 90
	X			
Дүн	T		1,2	
	Г		1,3	
	X		108	95

Арав. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт

Д\д	Хүрээлэн буй орчны хүчин зүйл	Хяналт шинжилгээ хийх байршил	Цэгийн дугаар	Хэмжих параметр	Хэмж давтамж	Зардал Мян. төг	Жилийн эцсийн тайлан
1	Агаарын чанар: а\ хийн хэмжилт NO _x ,SO _x , CO, O ₂	-уурхайн орчим -хүнд машин механизмын т орчим	Ц-1 Ц-2	Хүчил төрөгчийн давхар исэл, азотын исэл, нүүрстөрөгчийн исэл	8-р сар		БОАЖЯ, МХЕГ, Налайх МХХ
		г		Тоос, ус, хөрсний шинжилгээгээр стандарт хангасан тул хийгээгүй			
		х				0	0
	б\ тоос	Уурхайн орчим, Шигшүүр, Ажилчдын байр Т	Ц-3 Ц-4 Ц-5	Тоосжилтын түвшин	8-р сар		
		Г Шигшүүр, пускатель		1/ 33,2мг/м3 2/8,3мг/м3	9-р сар		MNS5010-2001
		Х		100			

2	Гадаргын болон гүний усны чанар\ундныус\	Т	Гүний худгаас	Ц-6	Усны химийн найрлага, бактерологи	7 сард	80.0	БОНХЯ, МХЕГ, УХЭГ, Налайх МХХ
		Г	Худгаас, Ундны ус	Ц-6	MNS ISO 0900-2005 ХАНГАСАН		64,5	
		Х			100		127,5	
3	Бохир ус	-	-	-	-	-	-	-
4	Хөрсөнд	Т	Хөрсний дээжид	Ц-7	Хөрсний чанарын үзүүлэлт	8-р сар		БОАЖЯ, МХЕГ, Налайх МХХ
		Г	2 ЦЭГЭЭС		Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан	9-р сар		MNS4943-2011 ХАНГАСАН
		Х			100			
5	Амьтан, ургамал, эрүүл ахуй	Т	Уурхайн орчим		-ургамал -амьтан -дуу шуугиан			Амьтан ургамлын байдалд тэмдэглэл
		Г	Уурхайн орчимд	2 цэгээс	-дулааны хэм -гэрэлтүүлэг -харьцангуй чийг -тоос		13,0	
		Х			100	9-р сард	100	100
Дүн		Т					180.0	
		Г					84,5	
		Х			80			

**Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
зардлын товчоо/биелэлт/-2022**

№	Арга хэмжээ	Сая төг.	
		төсөл	биелэлт
1	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	3,6	4,5
2	Байгаль орчны нөхөн сэргээх арга хэмжээ	4,5	3,5

3	Байгаль орчны хяналт шинжилгээ	0,2	0,1
4	Байгаль орчны менежмент	1,0	1,3
5	Дүйцүүлэх, химийн бодисын болон хог хаягдлын менежмент, тайлагнах	2,0	3,8
	Дүн	11,3	13,2
5	Үүнээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардагдах шууд зардал, сая төгрөг	9,4	13,2
6	Байгаль орчныг хамгаалах санд төвлөрүүлэх 50%	4,7	4,8

Тайлбар:* агаар, ус, хөрс, ургамал амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нөхөн сэргээлт, дүйцүүлэх арга хэмжээний дүнгээр тооцов.

УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

А.Хаягийн хэсэг: утас-99999047, майл хаяг: if.sons@yahoo.com

Байгууллагын нэр : Ай Эф Соонс ХХК								
Регистрийн дугаар:	2	7	4	1	2	8	8	
Нэр: Элстэйн гол код	1	5	3	1				
Аймаг, нийслэл : Улаанбаатар								
Сум,дүүрэг: Налайх								
Ашигт малтмалын төрөл: түгээмэл тархацтай а/м-элс								
Тусгай зөвшөөрлийн дугаар, талбай: MV-001903 11,4 га								
Олборлох баяжуулах технологи: Ил								
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн байгууллага: Их айлчин ХХК								
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн он	2	0	1	9				

Б. Уул уурхайн нөхөн сэргээлт

Үзүүлэлт				Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Хэмжээ
А				Б	В	Г
1.Олборлолт эхэлсэн он				1		2010
2. Олборлолтод өртсөн талбай	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Олборлолтод өртсөн газар	Гүн	2	м	6,2
			Талбай	3	га	7.76
			эзэлхүүн	4	Мян.м ³	481,1
		Гадаад овоолго	Өндөр	5	м	3
			Талбай	6	га	0.017
			эзэлхүүн	7	Мян.м ³	0.5
		Бусад	Гүн	8	м	
			Талбай	9	га	
			эзэлхүүн	10	Мян.м ³	
	Олборлолт явуулсан тайлант онд	Олборлолтод өртсөн газар	Гүн	11	м	9
			Талбай	12	га	0.272
			эзэлхүүн	13	Мян.м ³	24,5
		Гадаад овоолго	Өндөр	14	м	
			Талбай	15	га	
			эзэлхүүн	16	Мян.м ³	
		Бусад	Гүн	17	м	
			Талбай	18	га	

	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Олборлолтод өртөх газар	эзэлхүүн	19	Мян.м ³	
			Гүн	20	м	6,8
			Талбай	21	га	0.294
		Гадаад овоолго	эзэлхүүн	22	Мян.м ³	20.0
			өндөр	23	м	
			талбай	24	га	
		Бусад	эзэлхүүн	25	Мян.м ³	
			гүн	26	м	
			талбай	27	га	
			эзэлхүүн	28	Мян.м ³	
3. Техникийн нөхөн сэргээлт	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	29	га	1.84
			эзэлхүүн	30	Мян.м ³	51,6
		Гадаад овоолго	Талбай	31	га	
			эзэлхүүн	32	Мян.м ³	
		Бусад	Талбай	33	га	
			Эзэлхүүн	34	Мян.м ³	
	Олборлолт явуулсан тайлант онд	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	талбай	35	га	0.04
			эзэлхүүн	36	Мян.м ³	1,5
		Гадаад овоолго	талбай	37	га	
			эзэлхүүн	38	Мян.м ³	
		бусад	талбай	39	га	
			эзэлхүүн	40	Мян.м ³	
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Техникийн нөхөн сэргээлт хийх газар	талбай	41	га	0.04
			эзэлхүүн	42	Мян.м ³	0.8
		Гадаад овоолго	талбай	43	га	
			эзэлхүүн	44	Мян.м ³	
		Бусад	талбай	45	га	
			эзэлхүүн	46	Мян.м ³	
4. Биологийн нөхөн сэргээлт	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Биологийн нөхөн сэргээлт хийсэн	талбай	47	га	1.8
		Гадаад овоолго	талбай	48	га	

		Бусад	талбай	49	га	
	Олборлолт явуулсан тайлант онд	Биологийн нөхөн сэргээлт хийсэн	талбай	50	га	0.07
		Гадаад овоолго	талбай	51	га	
		Бусад	талбай	52	га	
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Биологийн нөхөн сэргээлт хийх	талбай	53	га	0.1
		Гадаад овоолго	талбай	54	га	
		Бусад	талбай	55	га	
5.Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө		Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр		56	Сая төг.	4.8
		Олборлолт явуулсан тайлант онд		57	Сая төг.	2,0
		Олборлолт явуулах төлөвлөгөөт онд		58	Сая төг.	2,0
6.Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан хөрөнгө		Олборлолт явуулсан үеэс, өссөн дүнгээр		59	Сая төг.	80,7
		Олборлолт явуулсан тайлант онд		60	Сая төг.	13,2
		Олборлолт явуулах төлөвлөгөөт онд		61	Сая төг.	10,0
7. Олборлолт явуулах төлөвлөгөөт онд		Хөрс хуулалт	талбай	62	га	
			хэмжээ	63	Мян.м ³	
		Хүдэр олборлолт, элс угаалт	талбай	64	га	0,25
			хэмжээ	65	Мян.м ³	20,0
		Бүтээгдэхүүн гаргалт		66	Мян.т	
				67	кг	
8. Олборлолтод ашиглагдах ус		Усны төрөл		68		
		Усны хэмжээ		69	Мян.т	
9. Химийн хорт, аюултай бодисын зарцуулалт		Зөвшөөрөгдсөн хэмжээ		70	Кг	
		Зарцуулсан хэмжээ		71	Кг	
10. Олборлолтод өртсөн ойн бүрхэвч		Талбайн хэмжээ		72	га	
		Мод		73	Тоо	

ЗАХИРАЛ

20.....оны.....р сарын.....ний өдөр